



ЮНЕСКО

Насан туршдаа
суралцахуйн институт

CONFINTEA VII



КОНФИНТЕА VII

Марракешийн үйл ажиллагааны хүрээ: Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын хувирган өөрчлөх хүчийг ашиглах нь



ТОВЧ АГУУЛГА

- 01** Оршил
- 05** Зарчим ба тэргүүлэх чиглэлүүд
- 08** Хувирган өөрчлөгч насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын төлөөх үйл ажиллагааны зөвлөмжүүд
 - 08** Үйл ажиллагааны бүтэцчилсэн хүрээ ба засаглалын тогтолцоог бий болгох нь
 - 09** Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын тогтолцоог шинээр зохион бүтээх нь
 - 11** Суралцахуйн чанарыг баталгаажуулах нь
 - 12** Санхүүжилтийг нэмэгдүүлэх нь
 - 13** Тэгш хамралтыг дэмжих нь
 - 14** Суралцахуйн ай, тэдгээрийг өргөжүүлэх нь
- 16** Баримт бичгийг баталж, хянаж үнэлэх олон улсын хамтын ажиллагаа

ИИМН
СУДАЛГААНЫ САН

ОРШИЛ

1. ЮНЕСКО-гийн гишүүн 142 орны төлөөлөгчид болон иргэний нийгмийн байгууллагууд, нийгмийн түншүүд, НҮБ-ын агентлагууд, засгийн газар хоорондын байгууллагууд, залуучууд болон хувийн хэвшлийн төлөөлөл бид 2022 оны 6 дугаар сарын 15-наас 17-ны өдрүүдэд Мароккогийн Хаант улсын Марракеш хотноо, биечлэн мөн онлайн хэлбэрээр Насанд хүрэгчдийн боловсролын долоо дахь олон улсын бага хурал (CONFINTEA VII)-д оролцлоо. Энэхүү бага хурал нь дэлхий дахины боловсролын тогтолцоо, тэр дундаа насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд гүнзгий нөлөөлсөн цар тахлын үеэр зохион байгуулагдаж байна.
2. Бид 2009 онд зохион байгуулагдсан CONFINTEA VI-аас хойш насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын салбарт гарсан томоохон ахиц дэвшил, тулгарсан сорилт бэрхшээлийг дүгнэж, дараагийн 12 жилд буюу 2030 он, түүнээс цааш насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг хөгжүүлэх замын зураг боловсруулах зорилгоор цугларсан.
3. Бид 2009 оны Белемийн Үйл ажиллагааны Хүрээг баталсан CONFINTEA VI-ийн ололтыг эргэн сануулж байна. Уг баримт бичигт насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг сурч боловсрох эрхийн салшгүй бүрэлдэхүүн гэж хүлээн зөвшөөрсөн бөгөөд, бодлого, засаглал, санхүүжилт, оролцоо, тэгш хамралт, эрх тэгш байдал, чанар зэрэг үйл ажиллагааны таван чиглэлийг тодорхойлсон нь өнөөдөр ч ач холбогдолтой хэвээр байна. Мөн ЮНЕСКО-гийн Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын дэлхийн тайлангийн үнэ цэнийг онцлон тэмдэглэж байна. Энэхүү тайланг 2009 оны Белемийн үйл ажиллагааны хүрээнд зааснаар насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын хүрээнд гарч буй өөрчлөлт, ахиц дэвшлийг тогтмол хянаж үнэлэх арга хэрэгсэл болгосон.



4. Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын дэлхийн тайлангийн тоо баримтад тулгуурлан 2009 оноос хойшхи насанд хүрэгчдийн суралцахуй, боловсрол болон насан туршийн суралцахуйг хөхиүлэн дэмжих чиглэлээр дэлхий дахины томоохон хүчин чармайлтуудыг эргэцүүлж байна. Үүнд олон улсын хамтын нийгэмлэгийн 2030 оны Тогтвортой хөгжлийн хөтөлбөр болон түүнд багтсан Тогтвортой хөгжлийн зорилгуудаар илэрхийлэгдсэн амлалт, насан туршийн суралцахуйг илүүтэй хүлээн зөвшөөрөх болсон “бүх хүнд тэгш хамарсан, эрх тэгш, чанартай боловсрол олгохх, насан туршдаа суралцах боломжийг хөхиүлэн дэмжих” Тогтвортой хөгжлийн 4 дүгээр зорилго,ба Боловсролын ирээдүйн талаарх олон улсын комиссын тайлан, насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын дэлхийн таван удаагийн тайлангаар дамжуулан сайжирсан насанд хүрэгчдийн боловсролын дэлхийн хяналт-шинжилгээ, Боловсролын хяналт үнэлгээний Дэлхийн тайлан, мөн Насан туршийн суралцахуйн хүрээнд хэрэгжиж буй Дэлхийн бичиг үсэг тайлагдалтын холбоо зэрэг санаачилга, түүнчлэн насанд хүрэгчдийн боловсролыг дэлхийн боловсролын бодлого, тогтолцоонд нэгтгэх чиглэлээр хийгдсэн алхмууд зэрэг багтана. Тиймээс Марракешийн үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхдээ явцад эрхэд суурилсан хандлага-арга зүйг удирдлага болгоно.
5. Бид КОВИД-19 цар тахлын урт хугацааны, тогтолцооны түвшинд үзүүлсэн нөлөө болон насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд үзүүлсэн харилцан адилгүй үр дагаврыг онцлон тэмдэглэж байна. Цар тахал нь засгийн газар болон орон нутгийн байгууллагуудыг залуучууд, насанд хүрэгчдэд хямралын үр дагаврыг даван туулахад туслах мэдлэг, ур чадвар, чадамж эзэмшүүлэх стратеги, суралцахуйн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх шаардлагад анхаарлаа хандуулахад хүргэсэн. Мөн нийгэм, хөдөлмөрийн зах зээлийн, ялангуяа ногоон болон дижитал шилжилтээс хамааран өөрчлөгдөж буй хэрэгцээг хангах ын тулд ур чадварыг дахин эзэмшүүлэх (re-skilling) болон ур чадварыг дээшлүүлэх (upskilling) стратегийг боловсруулах шаардлагатайг онцлон тэмдэглэж байна.





6. Бид Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2015 онд баталсан Тогтвортой Хөгжлийн 2030 хөтөлбөрийг эргэн сануулж, Тогтвортой Хөгжлийн 17 Зорилтод хүрэхийн төлөө тууштай ажиллаж байна. Бид насан туршийн суралцахуй нь НҮБ-ын 17 зорилго бүрт чухал ач холбогдолтой бөгөөд түүний үндсэн бүрэлдэхүүн хэсэг болох насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол нь эдгээр зорилгыг хэрэгжүүлэх гол түлхүүр болохыг хүлээн зөвшөөрч байна. Ялангуяа Тогтвортой хөгжлийн зорилго 4-ийн хүрээнд авсан амлалтаа дахин баталгаажуулж байна. Энэхүү зорилгын хүрээнд гишүүн улс орнууд “Бүх хүнд тэгш хамарсан, эрх тэгш, чанартай боловсрол олгож, насан туршдаа суралцах боломжийг хөхүүлэн дэмжих” үүргийг хүлээсэн. Бид 2021 оны 5-р сард батлагдсан Тогтвортой хөгжлийн боловсролын Берлиний тунхаглалыг эргэн сануулж, насанд хүрсэн суралцагчдыг түүний 16 зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хувь нэмрээ оруулахыг урьж байна. Мөн Боловсролын ирээдүйн талаарх олон улсын комиссын “Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь: Боловсролын нийгмийн шинэ гэрээ” тайланг хүлээн зөвшөөрч байна. Энэхүү тайланд хүний амьдралын туршид чанартай боловсролын эзэмших эрхийг баталгаажуулж, тогтвортой ирээдүйг цогцлооход боловсролын хувирган өөрчлөх хүч чадлыг нотолжээ.

7. Бид комиссын “насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын хүрээнд болон түүгээр дамжуулан бүх хүний эрх, жендэрийн тэгш байдлыг хангах” уриалгыг бүрэн дэмжиж байна. Мөн жендэрийн хэвшмэл ойлголтууд нь суралцагчдын суралцах үйл явцад идэвхтэй оролцох чадамжид нөлөөлдөг болохыг хүлээн зөвшөөрч байна. Жендэрийн хувирган өөрчлөх насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол нь цогц, иж бүрэн, үе хоорондын холбоостой байх ёстой бөгөөд боловсролын салбарт эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хууль зүйн зэрэг бусад салбарын, оролоцгч талуудтай хамтран ажиллахад чиглэгдсэн байх шаардлагатай.

ОИГМН
СУДАЛГААНЫ САН

8. Бид 2015 онд ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлаар батлагдсан Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол¹ын зөвлөмжийг (RALE) баримталж, Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын тодорхойлолт болон суралцахуйн гурван гол чиглэлийг тодорхойлсон. Үүнд: бичиг үсэг тайлагдалт ба суурь ур чадварууд; тасралтгүй боловсрол ба мэргэжлийн ур чадварууд; мөн либерал боловсрол (хүмүүнлэгийн), олон нийтийн оролцоот боловсрол болон хувь хүний хөгжлийн, амьдрах ухааны ба иргэн байх ур чадварт суралцах багтана.
9. Бид насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг насан туршийн суралцахуй²н үндсэн бүрэлдэхүүн хэсэг гэдгийг дахин нотолж, насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын бодлого, практик нь бүх насныхан, боловсролын олон түвшин, суралцахуйн янз бүрийн орон зай, хэлбэрт хамаарна гэдгийг тэмдэглэж, насан туршийн суралцахуй нь хувь хүн, гэр бүл, байгууллага, ажлын байр, оршин суугаа газар, хот, бүс нутгийг хамарсан янз бүрийн түвшинд суралцах суралцагч нийгмийн гол хөдөлгөгч хүч гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
10. Бид боловсрол, түүний дотор насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг хүний үндсэн эрх гэж баталж байна. Энэхүү амлалт нь Боловсролын Ирээдүйн талаарх Олон Улсын Комиссын баталсанчлан боловсролыг улс нийтийн үйл хэрэг, нийтийн сайн хэмээн ойлгож, тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг.
11. Мөн бид олон улсын насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын хамтлагууд болох төрийн, төрийн бус болон хувийн хэвшлийн оролцогч талуудын CONFINTEA VII-г зохион байгуулахад оруулсан олон талт, өргөн хүрээний байнгын хувь нэмрийг нь үнэлж байна. Үүнд бүс нутгийн болон орон нутгийн бэлтгэл бага хурал багтсан бөгөөд үр дүнгийн баримт бичгүүд нь Белемийн үйл ажиллагааны хүрээтэй хамт Сувоны CONFINTEA VI-ийн дунд хугацааны тойм тайлан, насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын дэлхийн тайлан, Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын зөвлөмж, ЮНЕСКО-гийн “Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь” тайлан нь энэхүү үйл ажиллагааны хүрээний үндэс суурийг тавьсан юм.
12. Нийгэмд хэт хэнээрхэл, хийрхэл (фанатизм), хүчирхийллийг дэвэргэсэн хэт туйлшрал (экстремизм) нэмэгдэж, шинжлэх ухаанд итгэх итгэл буурч, улс орнуудын дотор болон улс орнуудын хоорондын тэгш бус байдал нэмэгдэж байгаа энэ үед бид насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг нийгмийн эв зөийг бэхжүүлэх, нийгэм-сэтгэл зүйн ур чадварыг хөгжүүлэх, энх тайвныг бататгах, ардчиллыг бэхжүүлэх, соёлын харилцан ойлголцлыг сайжруулах, бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг арилгах, хамтдаа амар амгалан амьдрах, идэвхтэй, дэлхийн иргэний ба идэвхтэй иргэнийг бэлтгэх хүчтэй бодлогын хариу арга хэмжээ болж чадна гэдгийг дахин нотолж байна.
13. Бид 2022 оны 9-р сард болох Боловсролыг хувирган өөрчлөх дээд хэмжээний уулзалтын салшгүй хэсэг болгон Марракешийн үйл ажиллагааны хүрээний зөвлөмжийг таниулах үүрэг хүлээж байна. Марракешийн үйл ажиллагааны хүрээ нь уг дээд хэмжээний уулзалтанд ашиглагдах гол баримт бичиг болох ач холбогдолтойг эргэн сануулж байна.

ОИГ.МН
СУДАЛГААНЫ САН

1 Насанд хүрэгчдийн боловсрол нь насан туршийн суралцахуйн гол бүрэлдэхүүн хэсэг. Энэ нь залуучууд, насанд хүрэгчдийг ажил хөдөлмөр, нийгмийн амьдралд оролцуулах зорилготой суралцахуй ба боловсролын бүхий л хэлбэрийг багтаадаг. Энэ нь насанд хүрэгчид хувь хүний болон байгууллага, орон нутаг, нийгмийн ашиг сонирхлын тусын тулд амьдрах, ажиллах чадвараа сайжруулан хөгжүүлэх боломжтой албан ёсны сургалт, албан бус сургалт, амьдрах орчноосоо суралцах гэсэн суралцахуйн бүхий л үйл явцыг цогцоор нь илэрхийлдэг. Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол нь чадамж эзэмших, түүнийг хүлээн зөвшөөрүүлэх, туршлагаа солилцох, өөрчилж чадавхжих тогтвортой үйл явц, үйл ажиллагааг хамардаг. Залуучууд, насанд хүрэгчдийн ялгаа, зааг ихэнх соёлд өөрчлөгдөж байгааг харгалзан, тэд хууль ёсоор насанд хүрээгүй ч байсан насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд оролцож буй бүх хүмүүсийг “насанд хүрсэн хүн” гэсэн нэр томъёонд хамруулан ойлгоно (Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын талаарх зөвлөмж, 2015, х.6).

2 Насан туршийн суралцахуй нь үндсэндээ суралцах болон амьдрах гэсэн хоёр үйлийн нэгдлээр хэрэгжих бөгөөд суралцахуйн хэрэгцээ, шаардлагыг хангасан янз бүрийн хэлбэрээр (албан ёсны, албан бус, амьдрах орчноос), амьдралын өргөн хүрээнд (гэр бүл, сургууль, орон нутаг, ажлын байр гэх мэт) бүх насны хүмүүсийн (хүүхэд, залуучууд, насанд хүрэгчид болон ахмад настан, охид, хөвгүүд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд) суралцах үйл ажиллагааг хамардаг. Насан туршийн суралцах боломжийг дэмждэг боловсролын тогтолцоо нь бүх дэд салбар, түвшинг хамарсан цогц бодлого, Салбарыг өргөн хүрээнд хамарсан болон бүхэл бүтэн байдлаар хандах арга хандлагыг хэрэгжүүлж, хүн бүрт суралцах боломжийг хангахыг зорьдог. (Боловсрол 2030 Үйл ажиллагааны хүрээ, ЮНЕСКО 2015, х. 30, зүүлт 5)

ЗАРЧИМ ба ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛҮҮД

14. Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг насан туршдаа суралцахуйн хүрээнд дэмжих: Белемийн үйл ажиллагааны хүрээний тэргүүлэх чиглэлүүд одоо ч ач холбогдолтой хэвээр байгааг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ Тогтвортой хөгжлийн зорилго 4-ийн насан туршийн суралцахуйн гол бүрэлдэхүүн хэсэг нь насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол байгаа, ингэснээрээ тогтвортой хөгжил, ЮНЕСКО-гийн дүрэмд тунхагласан энх тайвны амлалтад жинтэй хувь нэмэр оруулах онцгой боломж олгож байна.
15. Нийгмийн шинэ гэрээг байгуулах нь: “Ирээдүйгээ хамтдаа дахин төсөөлөх нь” тайлангийн дүгнэлт, зөвлөмжөөс урам зориг авч, насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол нь хүний эрхэд суурилсан, ардчилсан нийгмийг бэхжүүлсэн, ёс зүйн зарчимд нийцсэн хүмүүнлэг хариу үйлдэл үзүүлэх, хамтын оюун санаа ухамсарыг дайчлах, салбар хоорондын мэдлэгээр баяжсан нээлттэй хэлэлцүүлгийг өрнүүлэхэд гол үүрэгтэй болохыг онцлон тэмдэглэж байна.
16. Сүүлийн жилүүдэд эмэгтэйчүүдийн бичиг үсгийн боловсрол болон бусад чиглэлэд гайхалтай ахиц дэвшил гарсан ч, олон улс орнуудад бичиг үсгийн болоод дижитал бичиг үсгийн түвшинг хангалттай хэмжээнд хүргэх, жендэрийн томоохон зөрүүг арилгах сорилттой тулгарсан хэвээр байна. 2021 онд 770 сая гаруй насанд хүрэгчид бичиг үсгийн суурь чадвар дутмаг байсан бөгөөд тэдний тавны гурав нь эмэгтэйчүүд байв. (UIS) Бичиг үсгийн боловсрол нь хувь хүн, гэр бүл, олон нийт, нийгэм мөн дэлхийн тогтвортой байдлын түвшинд үзүүлэх үр ашиг нь олон улсын судалгааны үр дүнгээр баталгаажсан тул насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролд бодлогын анхаарал тавих, тогтвортой санхүүжилт зориулах нэн шаардлагатай байна.



17. Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын нөөц боломж, чадавхыг уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд бүрэн ашиглах нь: Уур амьсгалын өөрчлөлт нь хүмүн төрөлхтөн төдийгүй бусад биологийн төрөл зүйлүүдэд асар том аюул занал учруулж байна. Уур амьсгалын өөрчлөлт нь биднээс өнөөгийн үйлдвэрлэл, хэрэглээний хэв загварыг эргэн харж, шинэ үйлдвэрийг бий болгон хөгжүүлэх, ирээдүй хойч үеийн өмнө ёс суртахууны үүрэг хариуцлагаа ухамсарлахыг шаардаж байна. Учир нь эх дэлхийгээ хайрлан хамгаалах нь хүн төрөлхтний хамтын үүрэг гэдгийг бүрэн ухамсарлах шаардлагатай. Тиймээс уур амьсгалын боловсролыг насан туршдаа суралцахуйн тогтолцооны салшгүй хэсэг болгон нэвтрүүлэх ёстой. Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол нь энэхүү ногоон өөрчлөлтийн нэг хэсэг байх ёстой. Ингэхийн тулд залуучууд, насанд хүрэгчдэд эдгээр асуудлын талаарх ойлголтыг өгч, тэдний мэдлэгийг дээшлүүлж, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөн зогсох чадлыг суулгаж, хувирган өөрчлөлт хийхэд гаардлагатай даван туулах чанар, эрх мэдлийг нь хөгжүүлэх хэрэгтэй боллоо. Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол нь насанд хүрэгчид болон ахмад настнуудыг чадавхжуулахад чухал үүрэг гүйцэтгэж, ингэснээр тэд орон нутгийн, үндэсний болон дэлхийн түвшинд хүүхэд залуучуудад үлгэр дууриал үзүүлж, өөрчлөлтийн хөдөлгөгч хүч болж чадна. Олон нийтийн оролцоот суралцахуй болон иргэний боловсрол нь хөдөө орон нутгийн хөгжил зэрэг тогтвортой хөгжлийн гол хүчин зүйл бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд гол үүрэгтэй. Цаашилбал, насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын байгууллагууд өөрсдөө сургалтын хөтөлбөр, барилга байгууламж, менежментээ ногоон болгосноор нийгэмд ногоон шилжилтийн загвар болж чадна.

18. Цахим, дижитал орчинд бүх суралцагчид төдийгүй ахмад настнуудын суралцах тэгш боломжийг дэмжих нь: Технологи нь насанд хүрэгчдийн суралцах болон заах арга барилд, мөн шаардлагатай мэдлэг, ур чадварын бүтцэд үлэмж өөрчлөлтийг авчирч байна. Энэ нь хувь хүний суралцахуйн хүчирхэг хурдасгуур, дэмжлэг болсон. Боловсролын хөгжилд технологи урагшлуулах хүч болж болох ч, нөгөө талаас нийгмийн ба хамтран суралцах үйл явцыг хүндрүүлж болзошгүй шинэ саадуудыг бий болгож, нийгэмд бий болсон ялгаатай байдлыг тэлэхийн зэрэгцээ шинэ ялгаа үүсгэх эрсдэлтэй байна. Үүнийг даван туулахын тулд бүх суралцагч цахим орчинд суралцах тэгш боломжтой байх нь зайлшгүй урьдчилсан нөхцөл юм. Тухайлбал, насанд хүрэгчид нийгмийн амьдралд идэвхтэй оролцох арга барилд суралцахын зэрэгцээ онлайн орчинд ташаа болон худал мэдээллийг таньж, түүнд зохистойгоор хариу үйлдэл үзүүлэхийн тулд шүүмжит сэтгэлгээ, харилцаа холбоо болон нийгмийн ур чадварын ач холбогдол улам нэмэгдэж байна. Үр нөлөөтэй стратеги, бодлого, хэрэгслүүдийг боловсруулах; дижитал хуваагдлыг арилгах; хүртээмжийг нэмэгдүүлэх; онлайн орчин дахь эрх мэдлийн харилцааг зохицуулах; технологийг буруугаар ашиглалтыг таслан зогсоох нь бүгд насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын хувирган өөрчлөх, эрх чөлөөнд хөтлөх хүч чадлыг бүрдүүлэхэд маш чухал юм. Үр дүнтэй дижитал сургах зүй нь танхимын,





зайнаас болон холимог хэлбэрээр заах, суралцах шинэ загваруудыг шаарддаг.

19. Насанд хүрэгчдийг ирээдүйн ажил хөдөлмөрт бэлтгэх нь: Хүн ам зүйн өөрчлөлт, аж үйлдвэрийн IV хувьсгал, даяарчлал болон уур амьсгалын өөрчлөлт нь эдийн засаг болон хөдөлмөрийн зах зээлд гүнзгий өөрчлөлт авчирч байна. Эдгээр өөрчлөлт нь ажил хөдөлмөрийн шинж чанар, ажил эрхлэлтийн бүтэц, ажлын агуулга, шаардлагатай чадамж, ур чадварт томоохон нөлөө үзүүлж байна. Олон жил давамгайлж ирсэн боловсролоос ажлын талбар луу шууд шилждэг шугаман зам улам бүр нийцгүй болж, насанд хүрэгчид ажил амьдралынхаа туршид илүү нарийн төвөгтэй замналаар явах хандлага эрчимжиж байна. Энэ нөхцөлд, оролцогч талуудын хамтын хариуцлагаар хэрэгждэг насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын зорилт нь уян хатан арга хэлбэрээр хүн бүрт амьдралынхаа туршид шаардлагатай мэдлэг, ур чадвар, чадамжийг эрх тэгш эзэмшүүлэх боломжийг бүрдүүлэхэд оршино. Үүнд ажил эрхлэлт, зохист хөдөлмөр, албан тушаал ахих, аж ахуй эрхлэхийг дэмжих мэргэжлийн чиг баримжаа олголт болон бусад суралцахуйн дэмжлэгүүд багтана. Хүн ам зүйн чиг хандлагаас харахад дэлхийн хүмүүсийн дундаж наслалт тасралтгүй нэмэгдэж байгаа нь дэлхий нийтээр өндөр настнуудын тоо өсөхөд нөлөөлж байна. Олон улс оронд хүн амын дийлэнх хэсэг нь хөдөлмөрийн зах зээлээс гарахын хэрээр насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын чиг хандлагыг өөрчлөх шаардлага үүсч байна. Үүнд ахмад настнуудыг ажил хөдөлмөрийн дараах үед бэлтгэх, тэдний нийгэмд үргэлжлүүлэн хувь нэмрээ оруулах боломжийг дэмжих, мөн тэдний сайн сайхан байдал болон амьдралынхаа бүхий л хүрээнд аз жаргалтай амьдрахад анхаарлаа хандуулах хэрэгтэй боллоо. Түүнчлэн нүүрстөрөгчийг саармагжуулах, хүрээлэн буй орчныг хамгаалахын тулд эдийн засагт хийх шаардлагатай өөрчлөлтүүдийг бий болгоход хөдөлмөрийн зах зээлд бэлэн байгаа насанд хүрэгчдийг дахин сургах, ур чадварыг нэмэгдүүлэх ажил хэргийг яаралтай эхлүүлэх хэрэгтэй байна.

20. Насан туршдаа суралцах соёлыг төлөвшүүлэх: Насан туршийн суралцахуй нь уур амьсгалын хямрал, технологийн болон хүн ам зүйн өөрчлөлтүүд, мөн COVID-19 цар тахлын бий болгосон сорилтууд болон түүнээс үүдэн нэмэгдсэн тэгш бус байдлыг багтаасан хүн төрөлхтний тулгарч буй сорилтуудыг шийдвэрлэх гол хүчин зүйл байх болно. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд насан туршийн суралцахуй ба боловсролын бүх хэлбэрийг (албан, албан бус болон амьдрах орчноос суралцах) болон бүх салбар, чиглэлийг хамарсан цогц хандлага шаардлагатай. Мөн танхимын, онлайн болон холимог сургалтын олон талт орчин, түүнчлэн ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын бүлгийг хамруулах хэрэгтэй. Иймээс бүх насны хүн ам, залуучууд, насанд хүрэгч, ахмад бүх хүмүүст зориулсан тэгш хамарсан, чанартай боловсрол болон насан туршдаа суралцахуйг зөвхөн хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг хангахын тулд бус, хувь хүний сайн сайхан байдал болон нийтийн сайн сайхны төлөө үйлчлэх олон нийтийн зорилтот үйл хэрэг болгон төлөвшүүлэх суралцахуйн орчныг бүрдүүлэх шаардлагатай.

ХУВИРГАН ӨӨРЧЛӨГЧ НАСАНД ХҮРЭГЧДИЙН СУРАЛЦАХУЙ БА БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗӨВЛӨМЖ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭ БА ЗАСАГЛАЛЫН ТОГТОЛЦООГ БИЙ БОЛГОХ НЬ

21. Боловсролын нийгмийн шинэ гэрээ шаардлагатай гэдгийг хүлээн зөвшөөрч, насан туршийн суралцахуйтай холбоотой өнөөгийн хүний эрхийн хүрээг бэхжүүлэх арга замын талаар холбогдох шинжээчдийн зөвлөлдөх уулзалт болон засгийн газар хоорондын хэлэлцээг эхлүүлэхийг ЮНЕСКО-д уриалж байна. Энэ үйл явц нь насанд хүрэгчдийн суралцахуйг төвдөө тавьсан насан туршдаа суралцах эрхийг бодит амьдралд хэрэгжүүлэх хамгийн оновчтой арга замыг эрэлхийлж, гишүүн улс бүрийн онцлогт тохирсон насан туршдаа суралцах соёлыг бий болгоход зорих ёстой.
22. Бид насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын засаглалыг дэмжихэд чухал яамд, иргэний нийгмийн байгууллагууд, залуучууд, хувийн хэвшил, их дээд сургуулиуд болон насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын үйлчилгээ үзүүлэгчид зэрэг холбогдох бүх оролцогч талуудыг хамарсан олон салбарын оролцоотой бүтцүүд чухал үүрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Мөн бид олон улсын туршлагаас харахад ажилчид, ажил олгогчдын хоорондын харилцан яриа, тэдгээрийн зохион байгуулалтын бүтцүүд нь засаглалд, ялангуяа мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжихэд чухал хувь нэмэр оруулдаг болохыг онцлон тэмдэглэж байна.



НАСАНД ХҮРЭГЧДИЙН СУРАЛЦАХУЙ БА БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООГ ДАХИН ЗАГВАРЧЛАХ НЬ

23. Суралцахуйн нарийн төвөгтэй экосистемийн нөлөөгөөр насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын үйлчилгээ нь олон төрөл, хэлбэртэй болж өргөжиж буйг харгалзан бид засгийн газруудын үүргийг бэхжүүлэх шаардлагыг дахин онцлон тэмдэглэж байна. Үүнд насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг дэмжих бүтэц, тогтолцоог дэмжих, боловсролын төрийн үйлчилгээг бэхжүүлэх хүрээнд насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг бүх нийтийн ба нийтийн сайн хэмээн үзэн зохицуулах, урамшуулах, дэмжих, уялдуулах, хянаж үнэлэхэд чиглэсэн зохицуулалт, механизмыг бий болгох, санхүүгийн болон хүний нөөцийг хуваарилах шаардлага багтана.
24. Бид орон нутгийн түвшинд насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг бэхжүүлэхийн ач холбогдлыг хүлээн зөвшөөрч, насанд хүрэгчдэд чиглэсэн сургалтын хөтөлбөрүүдийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, мөн мэргэшсэн насанд хүрэгчдийн багшаар сайн хангахын тулд олон нийтийн суралцахуйн төвүүд болон бусад сургалт, суралцахуйн санаачилгыг дэмжих, хамтран санхүүжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх шаардлага багтана. Мөн бид техникийн болон мэргэжлийн боловсрол, сургалт (TVET), их дээд сургуулиуд, номын сан, музей, ажлын байр, нийтийн зориулалттай газар, урлаг, соёлын байгууллагууд, спорт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газар, үе тэнгийн бүлгүүд, гэр бүл болон бусад олон төрлийн суралцахуйн орон зай байгааг хүлээн зөвшөөрч байна. Эдгээрийг орон нутгийн түвшинд бүх хүнийг насан туршдаа суралцах боломжоор хангахад чиглүүлэн институцийн чадавхыг нь бэхжүүлэх шаардлагатайг илэрхийлж байна. Жишээлбэл, суралцагч хотуудын хөгжлийг дэмжих, суралцагчид, иргэдийн бүлэг, байгууллагууд орон нутгийн оролцогч талуудын идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх нь чухал юм.





25. Цаашилбал, ажлын төрөл, салбар хооронд уян хатан суралцахуйн замналыг бий болгох гэсэн амлалт үүргийнхээ дагуу бид өмнөх суралцахуй болон суралцаж эзэмшсэн туршлагыг хүлээн зөвшөөрөх, түүнчлэн албан бус болон амьдрах орчноос суралцахуйг хүлээн зөвшөөрөх, баталгаажуулахын ач холбогдлыг онцолж байна. Энэ нь бүх хүн амыг, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй, бага орлоготой иргэд болох оролцоо багатай бүлгүүдийг уян хатан, нээлттэй суралцахуйн экосистемд нэвтэрч суралцах боломжийг бүрдүүлэх явдал юм. Үүнтэй холбоотойгоор боловсролын бүх түвшинд болон насан туршдаа суралцах үйл явцад нутгийн уугуул иргэдийг хамруулахад онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Уян хатан суралцахуйн замнал бүрдүүлэх нь сургалтын янз бүрийн хөтөлбөр, боловсролын түвшин, хөдөлмөр эрхлэлтийн салбар хооронд шилжилт хийх боломжийг суралцагчдад олгох гол нөхцөл юм. Ингэснээр суралцагчид өөрсдийн авьяас, сонирхолд тохирсон суралцах чиглэлээ сонгон, боловсролын дэд салбарууд болон хөдөлмөрийн зах зээлийн хооронд бий болгож буй холболтыг ашиглан хөгжих боломжтой болно.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУРАЛЦАХУЙН ЧАНАРЫГ БАТАЛГААЖУУЛАХ НЬ

26. Бид багш, сурган хүмүүжүүлэгчдийн түүнчлэн сайн дурын сургагч багш нар болон насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын үйл ажиллагаанд оролцдог бүх түвшний мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүргийг онцлон тэмдэглэж байна. Бид насанд хүрэгчдийн багш, сурган хүмүүжүүлэгчдийн ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн түвшинд бэлтгэх, нарийн мэргэшүүлэх бодлого, стратегийг хэрэгжүүлэхийг зорьж байна. Энэ хүрээнд их, дээд сургууль болон судалгааны байгууллагуудтай хамтран мэргэжлийн багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх болон тасралтгүй хөгжлийн сургалтаар насанд хүрэгчдийн сургагч-багш нарыг мэргэжлийн болгох, нарийн мэргэшүүлэх, ур чадварыг ахиулах; цалин хөлс, ажиллах нөхцөл, нийгмийн хамгаалал, мэргэжлийн хөгжил зэрэг багш, сурган хүмүүжүүлэгчдийн ажлын нөхцлийг сайжруулах бодлого, стратегийг хэрэгжүүлнэ. Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын чадамжийн хүрээг (competency framework) тэдний мэргэжлийн байдлыг нэмэгдүүлэх, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дээшлүүлэхэд ашиглах арга хэрэгсэл гэж хүлээн зөвшөөрч байна.
27. Бид насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд танхимын сургалтын чухал үүрэгтэйг онцлон тэмдэглэж, үл ялгаварласан, жендэрийн мэдрэмжтэй, нийцтэй сургалтын хөтөлбөр, сургалтын материалыг боловсруулж хэрэгжүүлнэ. Эдгээр нь дэлхийн иргэний боловсрол, тогтвортой хөгжлийн боловсрол, эрүүл мэнд ба сайн сайхны боловсрол, нийгэм – сэтгэлзүйн ур чадвар, ба зөөлөн буюу шүүмжит сэтгэлгээ, дижитал ур чадвар зэрэг суралцахуйн шинээр үүсэж буй чиглэлийг багтаана.
28. Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын чанарыг сайжруулахын тулд бид тэгш хамтран сургах, чанар, нийцийг цаашид хөхиүлэн дэмжих бодлого, практикийг чиглүүлэх судалгаа, үнэлгээ хийхийн ач холбогдлыг онцолж байна. Үүнд насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын хөтөлбөр боловсруулагчид, багш нар болон суралцагчдыг дэмжих зорилготой оролцоонд суурилсан судалгааг багтаах нь зүйтэй.



САНХҮҮЖИЛТИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ

29. Бид насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг дэмжих төрийн санхүүжилтийг нэмэгдүүлэх, нөөцийг дайчлах, одоо байгаа төсвийн хуваарилалтыг бууруулахаас сэргийлэх үүрэг амлалт өгч байна. Насан туршдаа суралцахуйн нэг бүрэлдэхүүн хэсэг болох насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг бусад яамд, ажил олгогчид, хувийн хэвшлийн байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа болон суралцагчид зэрэг олон оролцогч талуудын хувь нэмрээр санхүүжүүлэх шаардлагатай. Ийм санхүүжилтийн томъёо нь тогтмол өгөх төсвийг бусад эх үүсвэр, механизмтай, жишээлбэл холимог санхүүжилт болон эмэгтэйчүүд, эмзэг бүлэг, маргинал бүлгийн суралцагчдад чиглэсэн зорилтот арга хэмжээтэй хослуулах ёстой. Бид улс орны нөхцөл байдалд тохируулан насанд хүрэгчдийн боловсролд зориулсан төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх бөгөөд ДНБ-ий наад зах нь 4–6% эсвэл боловсролын нийт төсвийн 15–20%-ийг³ хуваарилах олон улсын жишигт хүргэх чиглэлд ажиллана.
30. Олон улсын хамтын ажиллагаагаар насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд шаардлагатай зохих санхүүжилтийг бүрдүүлэх үүргийг харгалзан, нөгөө талаас НҮБ-ын Тогтвортой хөгжлийн бүх 17 зорилтыг ахиулахад насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын оруулах хувь нэмрийг харгалзан бид боловсролын салбарт хөгжлийн туслалцаа үзүүлэх дэлхий нийтийн хамтын санхүүжилтийн механизмын өргөжүүлэхийг уриалж байна. Бид Тогтвортой хөгжлийн 4-р зорилтод хүрэх амлалтаа биелүүлэхийн тулд Боловсролын төлөөх дэлхий нийтийн түншлэл (GPE), “Боловсрол хүлээхгүй” сан (ECW) зэрэг дэлхийн боловсролын сангуудыг түнш орнуудад олгох стратеги, тэргүүлэх чиглэл, санхүүгийн дэмжлэгтээ насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг багтаахыг уриалж байна. Тогтвортой хөгжлийн 4-р зорилгын хүрээнд насанд хүрэгчдийн бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх, ур чадварын сургалтуудыг нэгтгэхийн тулд санхүүжилтийн цоорхойг нөхөх тал дээр ажиллах, мөн хөгжингүй улс орнуудын хөгжиж буй орнуудад зориулсан “Хөгжлийн албан ёсны тусламж”-ийн амлалт⁴ болох ДНБ-ийн 0.7 хувьд хүргэхийг зорино.

3 Эдгээр амлалт нь 2015 оны 5 дугаар сарын 21-нд Инчон хотод болсон Дэлхийн боловсролын форумаас гаргасан бөгөөд 2015 оны 11 дүгээр сарын 4-нд Парис хотод болсон ЮНЕСКО-ийн 184 гишүүн улс орнууд оролцсон өндөр дээд хэмжээний хурлаас баталсан болно.

4 Энэхүү амлалтыг ТХЗ-17, 17.2 зорилтын хүрээнд аль хэдийн өгсөн.



ТЭГШ ХАМРАЛТЫГ ДЭМЖИХ НЬ

31. Бид хэлний олон янзат байдлыг оролцуулан ялгаатай байдал, тэгш хамралт, хүртээмж, эрх тэгш байдлыг хүчин чармайлтынхаа гол цөмд тавих үүрэг хүлээдэг бөгөөд эдгээрийг гадуурхагдсан, маргинал бүлгийн, нийгэмд төлөөлөл хангалтгүй, эсвэл эмзэг бүлгийн хүн ам, болон иргэдийн оролцоог нэмэгдүүлэх дунд насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд хамрагдах боломжийг нэмэгдүүлэхэд тэргүүлэх чиглэлээ болгодог юм. Мөн тэгш байдал, хүртээмжийн зорилтуудыг хэрэгжүүлэхдээ уугуул иргэдийн нөхцөл байдал, тэдний хүлээх үүрэг хариуцлагыг онцгойлон анхаарч үзэх нь нэн чухал юм. Энэхүү амлалт нь боловсролыг хүний үндсэн эрх гэж дахин баталгаажуулсантай холбоотой бөгөөд үүнд эрхмэдэлжилт, идэвхтэй, дэлхийн иргэн байх боломжийг олгох оролцооны эрхийг мөн багтаана.
32. Бид насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын албан болон албан бус сургалтад насанд хүрэгчдийн оролцоог мэдэгдэхүйц нэмэгдүүлэх үүрэг болон улс орнуудыг олон янзын бүлгүүдийн суралцагчдын хамруулах жишиг үзүүлэлтийг өндөрсгөн тогтоохыг уриалж байна. Хамгийн эмзэг бүлгийн хүн ам болон боловсрол эзэмшээгүй, сургалтад хамрагдаж чадахгүй байгаа насанд хүрэгчдийг насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд хамруулахын тулд тэдэнд суралцах боломжийн талаарх ойлголт, мэдээлэл өгөх, оролцоог сайжруулах, суралцагчдын урам зоригийг нэмэгдүүлэх чиглэлээр хүрч ажиллах ба зөвлөн чиглүүлэх тогтолцоог дэмжихээр амлаж байна.
33. Бид насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд найдвартай, бодит, ил тод, хүртээмжтэй, жендэрийн мэдрэмжтэй мэдээллийн тогтолцоог хэрэгжүүлэхийн ач холбогдлыг дахин нотолж байна. Ийм тогтолцоо нь ялангуяа нийгмийн үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн ам, бүлгүүдийн тогтвортой оролцоо, ахиц дэвшлийг хянах, мөн засгийн газар, төрийн бус байгууллагууд, их дээд сургуулиуд, иргэний нийгмийн байгууллагууд болон гишүүн орнуудын хооронд мэдлэг мэдээлэл солилцох боломжийг олгох юм.



СУРАЛЦАХУЙН АЙ, ТЭДГЭЭРИЙГ ӨРГӨЖҮҮЛЭХ НЬ

34. Бид бичиг үсэгт тайлагдах байдлыг насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын үндэс суурийг бүрдүүлэгч, суралцахуйн болон суурь чадамжийн түвшний нэг хэсэг хэмээн бичиг үсгийн боловсролыг дахин баталгаажуулж байна. Бид үүнтэй холбогдох бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүчин чармайлтаа эрс нэмэгдүүлж, Тогтвортой хөгжлийн 4.6 зорилгын зорилтуудыг биелүүлэх үүрэг хүлээж байна. Үүнд цогц, нотолгоонд суурилсан, жендэрийн хувирган өөрчлөгч, салбар хоорондын, тэгш хамарсан бичиг үсгийн боловсролын бодлого, хэрэгжилтийн стратегийг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагаа багтана.
35. Бид ажлын байрыг нэгэн чухал суралцахуйн орчин гэж хүлээн зөвшөөрч байна. Ажлын байранд насан туршдаа суралцахуйн соёлыг төлөвшүүлэх нь зохист хөдөлмөр эрхлэх, ажлын байрандаа үргэлжлүүлэн ажиллах, улмаар ажлын шинэ шаардлагад дасан зохицож, хувь хүний хөгжил, өөрийнхөө зорилгод хүрэхэд чухал нөлөөтэй. Мөн ажлын байран дах суралцахуй нь илүү шударга, тэгш хамарсан нийгмийн цогцлоон байгуулахад хувь нэмэр оруулах ёстойг бид хүлээн зөвшөөрч байна. Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол нь ажлын бүтээмж, үр ашиг, сайн сайхан байдлыг дэмждэг тул ажил олгогчдыг ажлын байран дах насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд хөрөнгө оруулахыг бид уриалж байна.
36. Тогтвортой байдлын чухал хэсэг болох уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг авах арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрч, бид тогтвортой хөгжлийн боловсролыг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан, үр дагаврын талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх амлалт өгч байна. Ингэснээр бүх залуучууд, насанд хүрэгчид тогтвортой хөгжлийн тулгамдсан асуудлуудыг илүү сайн ойлгож, хэрэглээний хэв маяг, амьдралын дадал зуршлаа өөрчлөн, хүрээлэн буй орчныг хамгаалах, хадгалж үлдэх ардчилсан хэлэлцүүлэг, санаачилгад идэвхтэй оролцох замаар эрхмэдэлжсэн иргэн байж үйлдэл хийх боломж бүрдэнэ.
37. Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд технологи асар чухал үүрэгтэйг хүлээн зөвшөөрч, гишүүн орнууд иргэдийн дижитал хуваагдлыг багасгах, дижитал бичиг үсэг, ур чадварыг дэмжих арга замуудыг тодорхойлох, мөн мэдлэгт хүрэх боломжийг зохицуулсан ЮНЕСКО-гийн норматив баримт бичигт үндэслэн суралцахуйн шинэ чиглэлийг боловсруулах амлалт өгч байна. Үүнд 2019 оны Боловсролын нээлттэй эх сурвалжийг дэмжих зөвлөмж, 2021 оны Нээлттэй шинжлэх ухааны зөвлөмж, мөн хиймэл оюун ухааны хэрэглээнд чиглэсэн 2021 оны Хиймэл оюун ухааны ёс зүйн зөвлөмж тус тус багтана. Тиймээс насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол хамгийн их хэрэгцээтэй байгаа маргинал бүлгийн иргэд болон олон нийтэд хүрэх үр дүнтэй арга зам болох хосолсон сургалтыг дэмжихийн зэрэгцээ, нийтлэг болон нийтийн сайны төлөө нээлттэй боловсролын эх сурвалжийг дэмжиж, технологийг суралцахуйн зорилгоор ашиглах эрх тэгш байдал, тэгш хамралт, нууцлал болон ёс зүйн асуудлыг шийдвэрлэхийг зорьж байна.
38. COVID-19 цар тахлын нөлөөг харгалзан бид хувь хүн болон нийгмийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг дэмжихэд суралцахуйн ач холбогдлыг онцолж байна. Бид үндэсний болон орон нутгийн түвшинд насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын бодлого, хөтөлбөрт дээрх агуулгыг бэхжүүлэх шаардлагатайг хүлээн зөвшөөрч, насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын хүний эрүүл мэндэд, тэр дундаа ахмад настнуудад үзүүлэх эерэг нөлөөллийг ашиглахыг зорьж байна. Эрүүл мэнд, сайн сайхан байдлын төлөө суралцахуй нь Тогтвортой хөгжлийн зорилт 3 болон 4-ийг холбож, насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсрол болон эрүүл мэндийг олон салбарын бодлого, хөтөлбөрт шигтгэхийн ач холбогдлыг онцолж байна.



39. Бид нийгмийн өөрчлөлт, хөгжлийн сорилт бэрхшээлүүдийг даван туулахад идэвх оролцоотой, дэлхийн иргэний боловсрол, хэвлэл мэдээлэл, мэдээллийн суурь боловсрол олгохын ач холбогдлыг онцолж байна. Тиймээс насанд хүрэгчдэд зориулсан иргэний боловсролыг бэхжүүлэх санаачилгыг дэмжиж, суралцагчдын мэдээллийг шүүмжит өнцгөөс нягтлан шинжлэх, мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, өөрийн мэдэлтэй байх, улмаар олон нийтийн хэлэлцүүлэг болон орон нутгийн хөгжилд үр өгөөжтэй хувь нэмэр оруулах чадварыг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэхийг зорьж байна.
40. Бид Тогтвортой Хөгжлийн 2030 хөтөлбөрийг дасан зохицох чадамж (transversal competence)-ийг хөгжүүлэх замын зураг болгон ашиглахаар зорьж, энэхүү хөтөлбөр нь насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын олон талт зорилгыг ирээдүйтэй уялдуулан нэгтгэх чадамжтайг хүлээн зөвшөөрч байна. Чанартай боловсрол, насан туршдаа суралцахуй нь Тогтвортой Хөгжлийн Зорилго 4-ийн хэрэгжилтийн чухал механизм төдийгүй, ядуурлыг устгах (ТХЗ 1), эрүүл мэндийг дэмжих (ТХЗ 3), жендэрийн эрх, тэгш байдлыг хангах (ТХЗ 5), тэгш бус байдлыг бууруулах (ТХЗ 10), эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох (ТХЗ 8), ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих (ТХЗ 11), энх тайван, шударга ёсыг цогцлоох (ТХЗ 16), уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах (ТХЗ 13) зэрэг зорилтуудыг хангах урьдчилсан нөхцөл нь юм. Мөн түүнчлэн, насанд хүрэгчдийн боловсрол нь сурч боловсрох эрхийн салшгүй хэсэг бөгөөд хүний бүх эрхийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдийг бид онцолж байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ТУНХАГ БИЧГИЙГ БАТАЛЖ, ХЯНАХ ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

41. Энэхүү үйл ажиллагааны хүрээнд тусгагдсан амлалтуудыг хэрэгжүүлэх явцад гарсан шинэ мэдлэг, сайн туршлагыг тасралтгүй солилцох, харилцан суралцахуйг дэмжих, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулахын зэрэгцээ, олон улсын эв санааны нэгдлийн үзэл санаанд тулгуурлан бид насан туршдаа суралцахуйг дэмжих, насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролыг хөгжүүлэх зорилготой олон улсын хамтын ажиллагааны санаачилгуудад цаашид дэмжиж оролцохоо амлаж байна.
42. Бид ТХЗ 4 болон бусад ТХЗ-уудыг хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээлтэй тулгарч буй гишүүн орнуудад онцгой анхаарал хандуулах үүрэг хүлээж байна. Үүнд:
- Зөрчил, мөргөлдөөнд автсан гишүүн орнууд - дүрвэгсэд болон нүүлгэн шилжүүлсэн хүн амыг багтаасан насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд оролцох хэрэгцээ, чадавхыг бэхжүүлэх тал дээр тэдний ялгаатай хэрэгцээг харгалзан үзэх;
 - Жижиг арлын хөгжиж буй орнууд: Уур амьсгалын өөрчлөлтөөс болж улам бүр дордож буй бүтцийн эмзэг байдлыг харгалзан үзэх;
 - Африкийн орнууд: Боловсролын салбарт тулгамдсан удаан хугацааны сорилтуудтай тулгардаг хэрнээ, ирээдүйн хөгжлийн асар их боломжтой байдлыг харгалзан үзэх;
 - Хамгийн буурай хөгжилтэй орнууд: Тогтмол онцгой анхаарал, зорилтот дэмжлэг шаардсан хэвээр байгааг харгалзан үзэх;
43. Бид НҮБ-ын боловсролын тэргүүлэх байгууллага болох ЮНЕСКО-г гишүүн орнуудтай хамтран энэхүү Үйл ажиллагааны хүрээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, гарсан ахиц дэвшлийг тогтмол үнэлж, хянан шинжилж ажиллахыг урьж байна.
44. Бид энэхүү үйл ажиллагааны хүрээг дэлхийн, бүс нутгийн, үндэсний, дэд үндэсний болон орон нутгийн түвшинд холбогдох механизмаар дамжуулан урагшлуулах үүрэг хүлээж байна. Үүнд ТХЗ 4-ийн хэрэгжилтийн дэлхийн механизмд Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын дэлхийн тайлан (GRALE), Суралцахуйн хяналт шинжилгээний Дэлхийн холбоо (GAML), Бичиг Үсгийн Дэлхийн Холбоо (GAL), Боловсролын хяналт, шинжилгээний Дэлхийн тайлан (GEMR), ТХЗ 4—Боловсрол 2030 дээд түвшний Удирдах Хороо, Тогтвортой хөгжлийн асуудлаарх Дээд түвшний Улс төрийн Форум болон олон улсын түншүүд, төрийн бус байгууллагууд болон улс орнуудын түвшний хяналт-шинжилгээ зэрэг хамаарна. Бид Мароккогийн Хаант улсын санаачилгаар Африкийн Насан туршдаа суралцахуйн хүрээлэнг байгуулж байгааг талархан хүлээж авч байна.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

45. Насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын дэлхийн тайлангийн уламжлалд нийцүүлэн, найдвартай, хүчин төгөлдөр, ил тод, хүртээмжтэй мэдээлэл, мөн жендэрийн мэдрэмжтэй хяналт-шинжилгээний тогтолцооны шаардлагыг бид дахин онцолж байна. Энэхүү тогтолцоо нь Үйл ажиллагааны хүрээний хэрэгжилтийг тогтмол хянахад шаардлагатай холбогдох, нарийвчлан ангилсан өгөгдлийг бий болгож, гишүүн улсууд болон бусад насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд чухал оролцогч талуудын хооронд мэдлэг болон сайн туршлагыг солилцох дижитал платформуудыг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх ёстой.
46. Бид ЮНЕСКО-гийн Насан туршийн боловсролын Институтээр (UIL) дамжуулан насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролд гарсан ахиц дэвшлийг дэлхийн түвшинд тогтмол хянаж, тайлагнах хяналт-шинжилгээний үйл явцыг зохицуулахыг уриалж байна. Үүнд дэлхийн тайлан болон 2028 онд болох CONFINTEA VII-ын дунд хугацааны хэрэгжилт, ахиц дэвшлийн үнэлгээ зэрэг арга хэрэгслүүд багтана.
47. Мөн бид энэхүү үйл ажиллагааны хүрээний зөвлөмжийг үр нөлөөтэй, оролцооны зарчимд суурилсан хэрэгжилтээр хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор CONFINTEA VII-ын дараа яамд хоорондын комисс байгуулах тухай Мароккогийн Хаант Улсын санаачилгыг талархан хүлээн авч байна.
48. Иймд бид нийгмийн эв зетэй, тэгш хамарсан, тогтвортой ирээдүйг цогцлоохын төлөө насан туршийн суралцахуйн үзэл баримтлалд тулгуурлан насанд хүрэгчдийн суралцахуй ба боловсролын хувиран өөрчлөх хүчийг ашиглахад чиглэсэн Маракешийн үйл ажиллагааны хүрээ баримт бичгийг баталж байна.





ЮНЕСКО

Насан туршдаа
суралцахуйн институт

CONFINTEA VII



ОРЧУУЛСАН: Доктор (Ph.D). Б.Хонгорзул
РЕДАКТОР: А.САНЧИРМАА
ХЯНАСАН: Д.Тунгалаг
ДЭМЖИГЧ:



UII.MN
СУДАЛГААНЫ САН

Education
2030 